



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/077/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

᠒᠐᠒5.᠐᠒.᠒᠓ № 18᠖
танай ᠒᠐᠒5.01.2᠓-ны № 17᠗/᠐᠒ -т

Г МУИС-ИЙН ХАРЬЯА ДОРНОД АЙМАГ
ДАХЬ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
АХЛАХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ш.МАНДАХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймаг дахь МУИС-ын харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилго, 7 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг МУИС-ийн Зүүн бүсийн сургуулийн захирал 98.0 хувьтай үнэлсэн байна.

011022077

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,749,409.00	140,215,503.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50,221,264.00	71,510,898.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	50,221,264.00	71,510,898.00
3121	Төгрөг	50,221,264.00	71,510,898.00
31211	Төрийн сангийн харилцах	50,221,264.00	71,510,898.00
33	АВЛАГА		38,745,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага		38,745,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,528,145.00	29,959,605.00
354	Хангамжийн материал	18,528,145.00	29,959,605.00
35410	Бичиг хэргийн материал	526,000.00	118,800.00
35420	Аж ахуйн материал	210,290.00	
35470	Бусад хангамжийн материал	17,791,855.00	29,840,805.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	76,952,459.87	105,628,077.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	76,952,459.87	105,628,077.10
392	Биет хөрөнгө	76,769,126.67	105,628,077.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,084,652.00	145,431,306.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,251,076.10)	(53,041,005.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,310,141.00	18,754,381.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,374,590.23)	(5,516,604.28)
393	Биет бус хөрөнгө	183,333.20	-
39301	Програм хангамж	2,310,000.00	2,310,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,126,666.80)	(2,310,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	145,701,868.87	245,843,580.10
	НИЙТ ӨР ТӨЛБӨР		500,000.00
	Өглөг		500,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	145,701,868.87	207,098,580.10
51	Засгийн газрын хувь оролцоо		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	145,701,868.87	245,343,580.10
51200	Хуримтлагдсан үр дүн	145,701,868.87	245,343,580.10
51210	Өмнөх үеийн үр дүн	145,701,868.87	145,701,868.87
51220	Тайлант үеийн үр дүн		99,641,711.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	145,701,868.87	245,843,580.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	495,945,215.00	688,462,976.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,540,215.00	146,149,276.10
120	Нийтлэг татварын бус орлого	89,540,215.00	146,149,276.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,540,215.00	146,149,276.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,217,800.00	2,608,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	87,604,000.00	126,666,242.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	718,415.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		16,021,494.10

МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		852,740.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	406,405,000.00	542,313,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	420,198,884.11	588,821,264.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,198,884.11	588,821,264.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,198,884.11	584,778,764.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,763,081.00	442,686,030.00
210101	Үндсэн цалин	207,848,792.00	297,551,025.00
210102	Нэмэгдэл	82,494,100.00	125,176,189.00
210104	Урамшуулал	10,420,189.00	19,958,816.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,900,322.00	91,138,500.00
210201	Тэтгэврийн даатгал	24,472,183.00	37,000,539.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,244,250.00	4,375,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,577,200.00	2,182,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	598,355.00	2,182,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,008,334.00	8,497,239.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,540,000.00	10,449,462.00
210401	Бичиг хэрэг		312,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,540,000.00	10,137,062.00
2105	Нормативт зардал	33,906,000.00	
210502	Хоол, хүнс	33,906,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,397,500.00	6,491,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,003,800.00	3,683,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,393,700.00	2,808,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,691,981.11	70,914,094.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,396,482.00	34,952,534.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,090,600.00	12,846,284.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,204,899.11	23,115,276.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	4,042,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,042,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,042,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	75,746,330.89	99,641,711.23
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	75,746,330.89	99,641,711.23

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	494,866,800.00	631,243,742.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,821,800.00	88,930,042.00
120	Нийтлэг татварын бус орлого	88,821,800.00	88,930,042.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,821,800.00	88,930,042.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,217,800.00	2,608,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	87,604,000.00	86,321,242.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	406,045,000.00	542,313,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	406,045,000.00	542,313,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	445,776,885.00	609,898,108.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	445,776,885.00	609,898,108.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,776,885.00	605,855,608.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	297,660,739.00	440,586,030.00
210101	Үндсэн цалин	204,746,450.00	295,451,025.00
210102	Нэмэгдэл	82,494,100.00	125,176,189.00

МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Урамшуулал	10,420,189.00	19,958,816.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,002,664.00	54,238,178.00
210201	Тэтгэврийн даатгал	27,574,525.00	37,000,539.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,244,250.00	4,375,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,577,200.00	2,182,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	598,355.00	2,182,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,008,334.00	8,497,239.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,540,000.00	9,945,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,540,000.00	9,945,900.00
2105	Нормативт зардал	33,906,000.00	-
210502	Хоол хүнс	33,906,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,597,500.00	8,850,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,203,800.00	3,683,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,393,700.00	5,167,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,069,982.00	92,235,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,979,382.00	78,347,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,090,600.00	13,887,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	4,042,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,042,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,042,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,089,915.00	21,345,634.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	49,089,915.00	21,345,634.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,221,264.00	71,510,898.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			145,701,868.87	145,701,868.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			145,701,868.87	145,701,868.87
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			99,641,711.23	99,641,711.23
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			245,343,580.10	245,343,580.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		50,221,264.00	
11100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл			

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	679,464,400.00	609,898,108.00	69,566,292.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	679,464,400.00	609,898,108.00	69,566,292.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	675,421,900.00	605,855,608.00	69,566,292.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	501,479,700.00	440,586,030.00	60,893,670.00
210101	Үндсэн цалин	363,594,700.00	295,451,025.00	68,143,675.00
210102	Нэмэгдэл	128,399,100.00	125,176,189.00	3,222,911.00
210104	Урамшуулал	9,485,900.00	19,958,816.00	(10,472,916.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,685,000.00	54,238,178.00	8,446,822.00
210201	Тэтгэврийн даатгал	42,625,800.00	37,000,539.00	5,625,261.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,014,800.00	4,375,200.00	639,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,507,400.00	2,182,600.00	324,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,507,400.00	2,182,600.00	324,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,029,600.00	8,497,239.00	1,532,361.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,945,900.00	9,945,900.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,945,900.00	9,945,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,850,000.00	8,850,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,683,000.00	3,683,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	5,167,000.00	5,167,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,461,300.00	92,235,500.00	225,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,573,600.00	78,347,800.00	225,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,887,700.00	13,887,700.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,042,500.00	4,042,500.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,042,500.00	4,042,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,042,500.00	4,042,500.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	681,037,084.00	631,243,742.00	49,793,342.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	590,106,700.00	542,313,700.00	47,793,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	590,106,700.00	542,313,700.00	47,793,000.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	90,930,384.00	88,930,042.00	2,000,342.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,683,000.00	2,608,800.00	1,074,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	87,247,384.00	86,321,242.00	926,142.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50,221,264.00	(50,221,264.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		71,510,898.00	(71,510,898.00)
62	АЖИЛЛАГСДЫН ТОО		21	16
620001	Удирдах ажилтан		1	1
620002	Гүйцэтгэх ажилтан		18	13
620003	Үйлчлэх ажилтан		2	2

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 38.7 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Сурагчдын он дамжин төлөгдөх сургалтын төлбөрийн орлогыг санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулав. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Сургуулиас гарсан сурагчдын сургалтын төлбөрийн илүү төлөлтийг буцаан олгох учир тайланд өр төлбөрөөр бүртгэв. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 11.8 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв.

2.1 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг захирал 200 хувь, нягтлан бодогчид 100.0 хувиар тооцон 4.6 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тайлант хугацаанд ажилтны шамшигдуулсан 7.2 сая төгрөгийг авлага үүсгэж бүртгээгүй, цалингаас суутгалыг хийсэн. 9-11 сарын хугацаанд тус мөнгөнөөс 2.1 сая төгрөгийг цалингаас суутгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах заалттай нийцэхгүй толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сурагчдын он дамжин төлөгдөх сургалтын төлбөрийн орлогыг санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулав.	1	38,745.0					1	38,745.0				
Сургуулиас гарсан сурагчдын сургалтын төлбөрийн илүү төлөлтийг буцаан олгох учир тайланд	1	500.0					1	500.0				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

өр бүртгэв.	төлбөрөөр												
Дүн	2	38,745.0						2	38,745.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг захирал 200 хувь, нягтлан бодогчид 100.0 хувиар тооцон 4.6 сая төгрөгийг олгосон	1	4,559.0			1	4,559.0							
Тайлант хугацаанд ажилтны шамшигдуулсан 7.2 сая төгрөгийг авлага үүсгэж бүртгээгүй, цалингаас суутгалыг хийсэн. 9-11 сарын хугацаанд тус мөнгөнөөс 2.1 сая төгрөгийг цалингаас суутгасан	1	7,200.0			1	7,200.0							
Дүн	2	11,759.0			2	11,759.0							



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 784/19125199
ААА-2025/084/НА-СТА-ТМЗ

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУИС-ийн харъяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд сургалтын төлбөрийн орлогоос шамшигдуулсан 7,200,000.00 төгрөгийг ажилтнаас авах авлагаар бүртгээгүй, авлагын тулган баталгаажуулалт хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.9-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7 дох “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй”, 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, авлагыг бүртгэн тулган баталгаажуулалт хийж, авлагыг барагдуулах биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040470

2. Ажил гүйлгээ бүрийг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэн, үнэн зөв мэдээллээр хангах, хуулийг баримтлан ажиллахыг МУИС-ийн харъяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирал Ш.Мандах , нягтлан бодогч Г.Цэрэнсодном нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 058/140.5749
АНА - 2025/077/НА - СТА - ТМЗ

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан захирал, нягтлан бодогч нар 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 4,559,000.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040472

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг МУИС-ийн харьяа Дорнод аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирал Ш.Мандах , нягтлан бодогч Г.Цэрэнсодном нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ